### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зэрэг сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,411.6 сая төгрөгөөр буюу 70 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансдууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан/сая.төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /тоо/	Өөрчлөлт /хувь /
Мөнгөн хөрөнгө	66.30	141.90	-75.60	47%
Авлага	235.00	248.40	-13.40	95%
Бараа материал	211.40	244.70	-33.30	86%
Үндсэн хөрөнгө	7,509.60	10,798.80	-3,289.20	70%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,022.3</b>	<b>11,433.8</b>	<b>-3,411.50</b>	<b>70%</b>
Богино хугацаат өр төлбөр	12.1	11.30	0.80	107%
Цэвэр хөрөнгө, өмч	8,010.30	11,422.70	-3,412.40	70%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,022.4</b>	<b>11,434.0</b>	<b>-3,411.60</b>	<b>70%</b>

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 66.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 141.9 сая төгрөг болж 75.6 сая төгрөгөөр буюу 47 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 136.6 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд, үлдэх 5.3 сая төгрөг нь 2 орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын арилжааны банкны дансанд байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 235,0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 248,3 сая төгрөг болж 13.3 сая төгрөг буюу 10 хувиар өссөн байна.

Хүснэгт №02 Авлагын үлдэгдэл /сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.36	0.4	(0.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага		65.8	(65.8)
Байгууллагаас авах авлага	0.17	13.6	(13.4)
Хувь хүмүүсээс авах авлага	225.43	163.0	62.4
Зээлийн хүүгийн авлага	8.9	4.6	4.3
Татвар, НДШ /ОНӨААТҮГ/	0.1	0.9	(0.8)
<b>АВЛАГЫН НИЙТ ДҮН</b>	<b>235.0</b>	<b>248.3</b>	<b>13.3</b>

Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын үлдэгдэлд 63.1 хувь буюу 156.9 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага, 26.5 хувь буюу 65.8 сая төгрөг нь ЭМДС-гаас авах авлага, 5.0 хувь буюу 13.0 сая төгрөг нь ЕБС-ын самбарын урьдчилгаа авлага, үлдэх 2.7 хувь 1.2 сая

төгрөгийг бусад авлага эзэлж байна.

СХС-гаас бусад 91.4 сая төгрөгийн авлага нь дараа онд барагдах бүрэн боломжтой авлага байна.

СХС-гийн 156.9 сая төгрөгийн авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд оны эхэнд 233.6 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайлант хугацаанд зээл олгоогүй, 39.7 сая төгрөгийн зээл, зээлийн хүү эргэн төлөгдөж, оны эцэст 156.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Сангаас 2011-2017 онд олгосон 9 зээлдэгчтэй холбоотой 53.9 сая төгрөгийн авлага нь хугацаа хэтэрсэн авлага байна.

### **3.5.3 Бараа материал**

Бараа материалын дансны үлдэгдэл 244.7 сая төгрөг болж 33.3 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал, аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч зарцуулаагүйтэй холбоотой нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 339.4 сая, үнэ төлбөргүйгээр 38.5 сая, нийт 377.9 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 344.6 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

### **3.5.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 10,146.4 сая төгрөг байсан бол оны эцэст 13,635.4 сая төгрөг болж 3,581.3 сая төгрөгөөр өссөн нь 30.2 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авсан, 3,551.1 сая төгрөгийн өртөгтэй Зэрэг шим Ус ОНӨТТҮГ, Тээлийн илч ОНӨААТҮГ, Зэрэг сумын хуучин ЭМТ-ийн барилгуудыг аймгийн ОНӨГ-ын шийдвэрээр шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 30.2 сая төгрөгөөр төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн, 337.6 сая төгрөгөөр шилжүүлэн авсан, 3,213.4 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хандиваар нэмэгдэж, акталсан, балансаас балансад шилжүүлсэн 92.3 сая төгрөгөөр хөрөнгө хасагдсан байна.

### **3.5.6 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 12.1 сая, эцсийн үлдэгдэл 11.3 сая төгрөг болж 0.8 сая төгрөгөөр буурсан байна. Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 11.3 сая төгрөгийн өр байгаа нь дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой өглөгүүд байна. Өглөгийг нэр төрлөөр авч үзвэл: ажилчидтай холбоотой өглөг 0.8, бараа үйлчилгээний өглөг 1.3, байгууллагад өгөх өглөг 9.1 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэл байна.

### **3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч**

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 8,010.3 сая төгрөг байсан оны эцэст 11,422.7 сая төгрөг тайлант он 3,412.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 3,310.1 сая төгрөгийн үр дүнтэй, өмнөх үеийн үр дүн рүү 104.3 сая төгрөгөөр залруулсан тус тус нөлөөлсөн байна.

## **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,717.1 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2,717.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2,579.9 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2,728.8 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн Б/02 тоот тогтоолоор 2,885.3 сая төгрөгөөр 6 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,885.3 сая төгрөгийн төсөв баталснаас 1,875.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 778.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 34.6 сая төгрөгийг ЭМДС-аас, 131.7 сая төгрөгийг ОХНС-аас санхүүжих, 1.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 41.9 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас, 22.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

*Хүснэгт №3. Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төгрөг/*

Нэр төрөл	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
Улсын төсвөөс санхүүжих	1,875.5	1,824.7	50.80
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,875.5	1,824.7	50.80
Орон нутгийн төсвөөс санхүүжих	909.9	871.4	38.50
Орон нутгийн төсвөөс	778.2	739.7	38.50
Орон нутгийн хөгжлийн сан	131.7	131.7	-
Нийгмийн даатгалын төсвөөс санхүүжих	34.6	31.7	2.90
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	34.6	31.7	2.90
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	65.3	99.7	(34.37)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1.1	0.5	0.63
Туслах үйл ажиллагааны орлогоос	41.9	76.9	(35.00)
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22.3	22.3	-
<b>ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН</b>	<b>2,885.3</b>	<b>2,827.5</b>	<b>57.83</b>

*Эх сурвалж: Зэрэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1824.7, орон нутгийн төсвөөс 739.7, ОХНС-ийн санхүүжилт 131.7, ЭМДС-аас санхүүжих 31.7, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0.5, туслах үйл ажиллагааны орлогоос 76.9 сая, нийт 2,827.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,827.5 мянган төгрөгийг зарцуулж 57.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,717.1 сая төгрөг буюу 94.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 16.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.6, бараа хангамж, бараа материалын зардал, томилолтын зардал 2.9, нормативт зардал 37.0, хөрөнгийн зардал 54.6 сая төгрөгөөр буюу нийт 57.8 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.1, туслах үйл ажиллагааны орлого 41.9 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.5 сая, туслах үйл ажиллагааны орлогыг 76.9 сая төгрөгөөр нийт 77.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 76.9 сая төгрөгийг СХС-ийн зээл, зээлийн хүүгийн орлого, 0.5 сая төгрөг нь сумын соёлын төвийн өөрийн орлого бүрдсэн байна.

Зэрэг сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн Б/02 дугаар тогтоолд Зэрэг сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 165.2 сая төгрөгийн татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр

батлагдсанаас гүйцэтгэлээр 145.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 20.1 хувиар биелээгүй байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	165.2	145.1	20.1
<b>Нийт орлого ба тусламжийн дүн</b>	<b>165.2</b>	<b>145.1</b>	<b>20.1</b>
Татварын орлого	165.2	144.5	(12.2)
Орлогын албан татвар	17.7	24.9	(7.2)
<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>17.7</b>	<b>24.9</b>	<b>(7.2)</b>
Үйл ажиллагааны орлого	2.0	20.7	(18.7)
Суутгагчийн бусад орлого	15.7	4.2	11.5
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>29.3</b>	<b>33.0</b>	<b>(3.7)</b>
Бууны албан татвар	4.3	4.5	(0.2)
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	25.0	28.5	(3.5)
<b>Хөрөнгө борлуулсаны албан татвар</b>	<b>-</b>	<b>0.2</b>	<b>(0.2)</b>
Хөрөнгө борлуулсаны албан татвар		0.2	(0.2)
<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>4.1</b>	<b>5.2</b>	<b>(1.1)</b>
Бусад нийтлэг төлбөр, хураамж			-
Улсын тэмдэгтийн хураамж	1.9	2.7	(0.8)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	0.7	0.9	(0.2)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1.5	1.6	(0.1)
Газрын төлбөр	2.0	1.1	0.9
<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>112.1</b>	<b>80.1</b>	<b>32.1</b>
Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.5	0.7	(0.1)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	110.6	78.2	32.4
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1.0	1.2	(0.2)
Татварын бус орлого	-	0.7	(0.7)
Нийтлэг татварын бус орлого	-	0.7	(0.7)
Торгуулийн орлого		0.7	(0.7)

Нийт орлого 145.1 сая төгрөгөөр биелж 20.1 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого тасарсан шалтгаан нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ан амьтны нөөц ашигласны төлбөр 32.4 сая төгрөгөөр тасарсан нь гол нөлөө үзүүлсэн байна. Орлогыг нэр төрлөөр авя үзвэр хувь хүний орлогын албан татвар 7.2, хөрөнгийн албан татварын орлого 0.2, улсын тэмдэгтийн хураамж 0.8, татварын бус орлого 0.7 сая төгрөгөөр тус тус давж газрын төлбөр 0.8, байгалийн нөөц ашигласны төлбөр 32.1, төгрөгөөр тус тус тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар ЭМДС-аас Ковид-19 цар тахлын илүү цаг урамшуулал, эмийн зардалд 100.9, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 27.7, Статистикийн газраас судалгааны зардал 0.5, гадаадын төслөөс 8.0, бусад орлогоос 114.7 сая төгрөг нийт 258.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 251.8 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 6.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2010-2020 онуудад олгосон 116 зээлдэгчийн 315.4 сая төгрөгийн зээл олгогдсоноос 1 иргэн нас барсан 8.3 сая төгрөг төлөгдөөгүй, 69 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 33 иргэний 96.6 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 9 иргэний 53.9 сая төгрөгийн мянган төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 3.0 сая төгрөгийн бэлэн мөнгө, 7.7 сая хөрөнгө оруулалт, 19.2 сая төгрөгийн бараа материал, 26.1 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, нийт 56.0 сая төгрөгийн хандив цугларч 29.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 26.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэжээ.
3. Тайланд хугацаанд 670 хүн Ковид-19 цар тахлаар өвчилж 29.9 сая төгрөгийн нэг удаагийн эм, эмнэлгийн хэрэгсэл урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Зэрэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны бдугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор УТХО-оор 2016 онд хэрэгжсэн сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд зэрэг сумын ус, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээний ажлын 1,654.0 сая, Шим ус ОНӨААТҮГ 1,397.7 сая, 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 120 дугаар тогтоолоор цэргийн ангид өмнө шилжүүлсэн ЭМТ-ын 336.5 сая төгрөгийн өртөгтэй хуучин барилгыг данснаас дансанд шилжүүлсэн зэрэг суудлууд нь санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 157 мэдээллээс 148 хугацаандаа оруулсан 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 193.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгөгдсөн бөгөөд албан шаардлага бүрэн биелж, зөвлөмжийн хэрэгжилт 70 хувьтай хэрэгжүүлсэн байна. СХС-гаас авсан 8.0 сая төгрөгийн зээлтэй холбоотой зөвлөмж хэрэгжээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой сумын төсөвт байгууллагуудаас гаргасан зардлын зарцуулалт, гамшгийн сан бүрдүүлсэн 7.4 сая төгрөгийн өвсний зарцуулалтыг асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан, 2 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 7 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-2 (сумын 12 жилийн сургууль, сумын хүүхдийн цэцэрлэг), “Хязгаарлалттай” 1 (ЭМТөв) нийт 3 дүгнэлт гаргасан байна.

Зэрэг сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 52. сая төгрөгийн 13 алдаа зөрчил илэрч, 17.0 сая төгрөгийн 5 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 35.0 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 0.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт тогтоон, 17.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага өгч, 17.1 сая төгрөгийн 5 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5. Аудитад хамрагдсан байгууллагын судалгаа

/сая.төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зэрэг сумын ЕБС	3	5.70	2	4.20	0	0	0	0	1	1.50
2	Зэрэг сумын хүүхдийн цэцэрлэг	3	9.50	2	8.90	0	0	0	0	1	0.60
3	Зэрэг ЭМТ	7	36.80	1	3.90	1	0.8	2	17.1	3	15.00
<b>Дүн</b>		<b>13</b>	<b>52.00</b>	<b>5</b>	<b>17.00</b>	<b>1</b>	<b>0.8</b>	<b>2</b>	<b>17.1</b>	<b>5</b>	<b>17.10</b>

[Эх сурвалж:](#) Зэрэг сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

## 4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 379.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 37.4 сая төгрөгийн алдааг 3 алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 219.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 122.4 сая төгрөгийн 8 зөвлөмж өглөө.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгө орлогод бүртгэхдээ 2.2 сая мотор бүртгээгүй, 8.8 сая төгрөгийн сэлэнгэ үүлдрийн бух орлого дутуу бүртгэсэн, дуудлага худалдаагаар худалдан борлогдсон фермер автомашин, цахилгааны байр зэрэг хөрөнгө хасаагүй, нийт 37.4 сая төгрөгийг залруулсан,
2. Зэрэг Тээлийн илч, Шим ус орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд Шилэн дансны цахим системд оруулбал зохих аудитын тайлан, дүгнэлт, хэрэгжүүлсэн ажил, хагас бүтэн жилийн санхүүгийн тайлан, 5 сая төгрөгөөс дээш цалингаас бусад үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын зарлагын дүнг тус тус мэдээлээгүй байсныг нөхөж мэдээлсэн.

#### 4.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт:1. Зэрэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, нарийн бичгийн дарга нарт гар утасны ярианы төлбөр 0.2 сая төгрөг олгосон,

Илрүүлэлт:2. Засаг дарга, орлогч дарга, тамгын газрын дарга нар гар утасны ярианы төлбөр 0.4 төгрөгийг төлсөн, шагнал урамшуулал, бараа материалаас ХХОАТ 10 хувийн ашгийн татвар суутгаагүй 0.1 сая, томилолт илүү олгосон 0.1 сая, нийт 0.6 сая илүү олгосон

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлүүлэх 1.0 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

Илрүүлэлт1: Сумын ЗДТГ нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлээгүй Үүнд:1. Төсвийн гүйцэтгэлийн 1,2 дугаар сарыг мэдээлээгүй, хэтрэлт, хэмнэлт, тайлбарыг бичээгүй, 2,3 дугаар улирлын батлагдсан төсөв оруулаагүй, хөлийн дүн тавиагүй, 8 дугаар сар хугацаа хоцорсон, 2021 оны хагас, 2020 оны бүтэн жилийн тайлан мэдээлээгүй, 2020 оны аудитын дүгнэлт мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш цалингаас бусад үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ болон 5 саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын зарлагын дүнг тус тус мэдээлээгүй

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Илрүүлэлт 2: Сум хөгжүүлэх сангаас 2011-2017 онуудад зээл авсан 9 зээлдэгч 53.9 сая төгрөгийн зээл авсан бөгөөд одоог хүртэл төлөөгүй, хугацаа хэтрүүлэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулсаар байна. Энэ нь нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 5.4-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д " төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалтууд болон сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний 2.2-д "зээлийн үндсэн төлбөрийг дор дурдсан зээлийн эргэн төлөлтийн дагуу төлж дуусгана", 2.4-д" энэхүү гэрээний 2.2-д заасан зээлийн эргэн төлөлтийн хуваарьт заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөр, хүүгээс гадна төлөгдөөгүй үндсэн зээлийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зээлийн дүнгийн 0.5 хувийн алданги төлнө.", 5.3-д "энэхүү гэрээтэй холбогдсон аливаа маргаантай асуудлыг 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэх боломжгүй бол асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Илрүүлэлт 3: Нэгтгэсэн тайланд бүртгэлтэй суудлын автомашины судалгаанаас үзэхэд 15.9 сая төгрөгийн өртөгтэй ХОУ-0185 дугаарын Приус-20 маркийн автомашин байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

#### **4.4. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **4.4.1 Авлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Зэрэг сумын ТТЗ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд нэгтгэсэн Зэрэг шим Ус ОНӨҮГ 0.7 сая, Тээлийн илч 7.8 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлага, өглөгийг тус тус хугацаа хэтрүүлсэн. Энэ нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалт хэрэгжээгүй байна.

Өгсөн зөвлөмж Сумын ТТЗ-ын нэгтгэл тайланд авлагын үлдэгдлээр тайлагнасан хугацаа хэтэрсэн авлагуудыг бууруулах талаар үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэн төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах

##### **4.4.2 ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ОНХС-гаас 2021 онд хэрэгжүүлсэн Цагдаагийн байрны тохижилтын 2.3 сая, хүнсний ногооны үрийн шинэчлэл хийхэд олгосон 2.6 сая, нийт 5.9 сая төгрөгийн орлогыг бүртгээгүй байна.

Өгсөн зөвлөмж : Цагдаагийн байрны хөрөнгө оруулалтын ажлын хөрөнгө, бараа материалыг холбогдох журмын дагуу ашиглагч байгууллагад, хүнсний ногооны үрийг гэрээний дагуу ЗДТГ-т бүртгэн үрийн эргэцийг тооцон ажиллах

##### **4.4.3 ОНХС-гийн зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ОНХС-гаас Гамшгаас хамгаалах, сумын аюулгүй нөөц бэлтгэхэд 7.4 сая төгрөгийн өвсний нөөц бэлтгэж сумын ЗДТГ-т бүртгэсэн, Сумын Эрүүл мэндийн төвд ЭМД-аас санхүүжилт гүйцэтгэлээр олгосон байхад 5.0 сая төгрөгийн эм,эмнэлгийн хэрэгслийн үнэ олгосон байна.

Өгсөн зөвлөмж : ОНХС-гийн эх үүсвэрээр бэлтгэсэн өвсийг борлуулж, ЭМТ-д тоот илгээн 5.0 сая төгрөгийн эх үүсвэрийг буцаан авч ОНХС-гийн эр үүсвэрийг нэмэгдүүлэн ажиллах

##### **4.4.4 Шатахууны зарцуулалт, дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож албан хэрэгцээнд зарцуулдаг болон Засаг даргын Тамгын газрын ХОА 05-10 дугаарын УАЗ ПАТРИОТ маркын авто машинд шатахуун олгосон нь явсан ажлын тайланг хавсаргаж оруулаагүй, замын хуудас дутуу, жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй, тээврийн хэрэгслийн хувийн хэрэг байхгүй, дугуй худалдаж авсан, урсгал засварууд хийгдсэн техникийн комиссын дүгнэлт байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт

тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

**Өгсөн зөвлөмж:** Шатахууны тооцоог тухай бүр бодож, замын хуудсаар тооцоо хийж хэвших

#### 4.4.5 И баримттай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Сумын ЗДТГазар 24.8 сая төгрөгийн бараа материал худалдан авахдаа бараа бүтээгдэхүүнүүдэд гарсан зардлуудыг баримтжуулахдаа и баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг хэрэгжилт сумын хэмжээнд хангалтгүй байна.

**Зөвлөмж:** Сумын төрийн сангаас зардлыг санхүүжүүлэхдээ и баримтаар баталгаажуу ажил гүйлгээг гаргахгүй байх,

#### 4.4.6 Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бараа материал худалдан авч бэлтгэхдээ нярваар орлого аваагүй. Мөн эд хариуцагчийн карттай тулган үндсэн хөрөнгийн тооллого хийсэн ч тооллогын бүртгэл гарын үсэггүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Бараа материал худалдан авсан тухай бүрт нярваар орлого авхуулж, зарлагадахдаа нярав нь албан хаагчдаар шаардах хуудас бүрэн бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж зөвшөөрсөн тохиолдолд олгож хэвших, бараа материалын үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулж, хяналт тавин үнэн зөв бодитой тооллого хийх

#### 4.4.7 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

**Илрүүлэлт:** Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, хөрөнгө бэлтгэсэн, бусад арга хэмжээний зардлуудыг санхүүжүүлж төсвийг үр ашиггүй үрэлгэн зарцуулан байна. Мөн батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй.

**Зөвлөмж:** Засгийн газраас гаргасан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж батлагдсан төсвийг хэмнэлттэй байхаар зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хүснэгт 5. Аудитад хамрагдсан байгууллагын зөрчлийн судалгаа

/сая.төгрөг/

д/д	байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	1	15.9			0	0.0	1	15.9		

2	Зэрэг ЗДТГ	7	283.0	1	37.4	1	0.7	1	149.3	4	95.6
3	Зэрэг ИТХ	1	0.2			1	0.2				
4	Зэрэг Соёлын төв	-	-	-	-						
5	Зэрэг ОНХС	2	18.3							2	18.3
6	Зэрэг СХС	1	53.9					1	53.90		
7	Зэрэг Шим Ус	2	0.7	1	-					1	0.7
8	Зэрэг Тээлийн илч	2	7.8	1	0					1	7.8
<b>Дүн</b>		<b>16</b>	<b>379.8</b>	<b>3</b>	<b>37.4</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>3</b>	<b>219</b>	<b>8</b>	<b>122.4</b>

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**